

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

Хуралдааны товч тэмдэглэл: 1-2

Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл: 3-9

*1. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын
“Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн
үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төсөл /Засгийн газар
2024.08.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/* 3-9

**Монгол Улсын Их Хурлын
Төсвийн байнгын хорооны
2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 46 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Д.Батлут;

Тасалсан: Н.Алтанхуяг, Б.Батцэцэг, Ж.Баясгалан, Х.Болормаа, Ж.Ганбаатар, Г.Ганбаатар, Х.Ганхуяг, З.Мэндсайхан.

Нэг.Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төсөл /Засгийн газар 2024.08.27-ны өдөр өргөн мэдүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Эрчим хүчний яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Б.Ерэн-Өлзий, мөн яамны Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Г.Энхтүвшин, мөн хэлтсийн ахлах шинжээч Б.Пунцагбалжир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, референт Б.Мөнгөн-Аргамж нар байлцав.

Хуулийн төслийн талаар Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар, Р.Батболд нарын тавьсан асуултад Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Түвшин, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Ц.Даваасүрэн: Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын “Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай” хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явууля.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 6

Бүгд: 16

62.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 09 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 23 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 16 гишүүн хүрэлцэн ирж, 64.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 09 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
15 цаг 46 минут.

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Өнөөдрийнхөө хуралдааныг эхэлнэ хэдүүлээ. Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амар амгаланг айлтгая. Байнгын хорооны хуралдаанд ирэх ёстой 25 гишүүнээс 13, ирц 52 хувьтай байгаа учраас хуралдааны ирц бүрдсэн тул хуралдааныг эхлүүлэе. Ирсэн гишүүдийн ирцийг би танилцуулъя. Тилеуханы Аубакир гишүүн, Жигжидийн Батжаргал гишүүн, Цэрэнпиллийн Даваасүрэн гишүүн, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн, Далайн Батбаяр гишүүн, Хүрэлбаатарын Булгантуяа гишүүн, Гонгорын Дамдинням гишүүн, Ганзоригийн Тэмүүлэн гишүүн, Баттогтохын Чойжилсүрэн гишүүн, Ринчиндоржийн Батболд гишүүн, Пүрэвжавын Ганзориг гишүүн, Баатаржавын Мөнхсоёл гишүүн, Банзрагчийн Түвшин гишүүн, Даваахүүгийн Пүрэвдаваа гишүүн бүртгүүлэе орчихсон байна. Ингээд 14 гишүүн ирцэд бүртгүүлсэн байна.

**Нэг.Монгол Улсын Засгийн газар,
Оросын Холбооны Улсын Засгийн газар
хоорондын “Дулааны гуравдугаар
цахилгаан станцын өргөтгөл,
шинэчлэлийн төслийн үндсэн зураг,
төсөл боловсруулах тухай”
хэлэлцээрийн төсөл /Засгийн газар
2024.08.27-ны өдөр өргөн мэдүүлсэн,
зөвшилцөх/**

Хэлэлцэх асуудлыг би та бүхэнд танилцуулъя. Монгол Улсын Засгийн газар Оросын Холбооны Улсын Засгийн газар

хоорондын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай хэлэлцээрийн төсөл. Бид нар хэлэлцээд санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлэхээр байгаа.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна. Монгол Улсын ЗГ, ОХУ-ын ЗГ хоорондын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай хэлэлцээрийн төслийн хэлэлцүүлгийг эхэлье. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн, Батмөнхийн Ерэн-Өлзий Эрчим хүчний бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Ганбаатарын Энхтүвшин Стратеги, төлөвлөлтийн хэлтсийн дарга Эрчим хүчний яамны, Батмөнхийн Пунцагбалжир Эрчим хүчний яамны ахлах шинжээч гэсэн ийм улсууд оролцож байна.

Монгол Улсын ЗГ, ОХУ-ын ЗГ хоорондын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай хэлэлцээрийн төслийн талаарх илтгэлийг Эрчим хүчний сайд Баттогтохын Чойжилсүрэн танилцуулна. Чойжилсүрэн гишүүний микрофоныг өгье.

Б.Чойжилсүрэн: Эрхэм Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын ЗГ-ын 2024 оны 4 дүгээр сарын 17-ны өдрийн хуралдааны 15 дугаар тэмдэглэлийн дагуу дулааны гуравдугаар цахилгаан станцын суурилагдсан хүчин чадлыг цахилгаанаар 300мвт-аар, дулаанаар 395мвт-аар үе шаттай өргөтгөн шинэчлэх төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх хүрээнд Монгол Улсын ЗГ, ОХУ-ын холбооны газрын ЗГ хооронд байгуулах Дулааны

гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг, төсөл боловсруулах тухай хэлэлцээрийн төслийг боловсруулан 2024 оны 4 дүгээр сард ОХУ-ын Эрчим хүчний сайдад хүргүүлсэн.

ОХУ-ын ЭХЯ-наас уг хэлэлцээрийн төсөлд ОХУ-ын ЗГ-ын холбогдох яамдын саналыг авч тусган, хариу саналыг 2024 оны 7 дугаар сард ирүүлсэн. Тус хэлэлцээрийн төсөлтэй холбоотой зарчмын зөрүүтэй асуудлаар 2 улсын ЭХЯ хооронд 2024 оны 8 дугаар сард харилцан зөвшилцөж ажиллалаа. Мөн Оросын Эрчим хүчний сайдын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Сорокиноос 2024 оны 8 дугаар сарын 21-ний өдөр ирүүлсэн 13/232/ND/ тоот албан бичигт 2024 оны 9 дүгээр сард зохион байгуулагдах Монгол Улс ОХУ-ын Ерөнхийлөгч нарын уулзалтын үеэр энэхүү хэлэлцээрийн төсөлд гарын үсэг зурах арга хэмжээг зохион байгуулах саналаа илэрхийлсэн. Хэлэлцээрийн төслийг ЗГ-ын хуралдаанаар хэлэлцэж, дэмжсэн тохиолдолд Олон улсын гэрээний тухай хуулийн хүрээнд Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороотой урьдчилан зөвшилцөх бөгөөд Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны дүгнэлтийг үндэслэн Ерөнхий сайдын захирамжаар хэлэлцээрт гарын үсэг зурах эрхийг Эрчим хүчний сайд сайдад олгож, улмаар хэлэлцээрийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлж соёрхон батлуулна.

Энэхүү хэлэлцээрийн төсөл нь нийт 11 зүйлтэй бөгөөд тус хэлэлцээрт Дулааны гуравдугаар цахилгаан станцын өндөр даралтын хэсгийг 50мвт-ын блок станцаар өргөтгөх, дунд даралтын хэсгийн 48мвт-ын блок станцыг буулгаж, суурин дээр нь 250мвт-ын блок станц шинээр барих төслийн зураг, төсөл боловсруулах инженерийн судалгаа, шинжилгээ явуулах ажлын цар хүрээ, ерөнхий нөхцөлийг тодорхойлж, захиалагчаар Дулаан, цахилгаан станц 3 ТӨК, гүйцэтгэгчээр Оросын талаас эрх олгосон Интер РАО Экспорт экспорт

компанийг томилох асуудлыг тус тус зохицуулахаар тусгасан.

Зураг, төслийн ажлын үр дүнд Дулааны гурав дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн барилга угсралтын ажлын нийт төсөвт өртөг, хугацааг нарийвчлан тодорхойлж, цаашид ОХУ-ын ЗГ-ын экспортын зээлийн нөхцөл, барилга угсралтын ажил гүйцэтгэх зэрэг асуудлыг Оросын талтай хэлэлцэн тохиролцох нөхцөлийг бүрдүүлэх үндсэн баримт бичиг юм.

Монгол Улсын Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Олон улсын гэрээний тухай хуулийн хүрээнд хэлэлцээрийн төсөл, ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төсөл болон Ерөнхий сайдын захирамжийн төсөлд ЗГ-ын гишүүдээс санал авч, нэгтгэн танилцуулж байна. ЗГ-ын гишүүдээс нийт 25 санал ирснээс 5 саналыг хүлээн авч, 20 санал тайлбарласан болно.

Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн зураг, төсөл боловсруулах тухай Монгол Улсын ЗГ, ОХУ-ын ЗГ хоорондын хэлэлцээрийн төсөл болон ЗГ-ын хуралдааны тэмдэглэлийн төслийг та бүхэнд ирүүллээ. Хэлэлцэн шийдвэрлэж өгнө үү. Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Чойжилсүрэн сайд баярлалаа. Монгол Улсын ЗГ, ОХУ-ын ЗГ хоорондын Дулааны гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай хэлэлцээрийн төсөл, танилцуулгатай холбогдуулаад асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Цогтбаатар гишүүн асуух юм уу? Цогтбаатар гишүүн асууя. Цогтбаатар, Батболд гишүүнээр тасаллаа. Цогтбаатар гишүүн асуултаа асууя.

Дав.Цогтбаатар: Баярлалаа. Байнгын хорооны гишүүдэд өдрийн мэнд,

ажлын хэсэгт өдрийн мэнд. Энэ би ерөөсөө өмнө нь бол нэг их анзаараагүй явж байсан юм байна. Энэ одоо энэ гуравдугаар цахилгаан станцын өргөтгөл юм байна гээд. Тэгээд сая жосоохон анхаараад унисан чинь асуултууд аймаар олон гарч ирээд байна. Жишээлэхэд энэ зээлийн нөхцөл 2 хувь, эргэн төлөгдөх хугацаа 20 жил, үндсэн төлбөрөөс чөлөөлөх хугацаа 5 жил, Монголын талын хөрөнгө оруулалт 5 хувиас хэтрэхгүй, рублийн зээл авах сонирхолтой байгааг мэдэгдсэн гээд энэ жишээлэхэд хэний сонирхол Оросынх юм уу, Монголынх юм уу? Энийг би сая энэ Булгантуяа даргаас тодруулчихлаа.

Тэгээд энэ зураг, төсөл гээд яваад байгаа. Тэгж явж байснаа дахиад өргөтгөл, шинэчлэл гээд дахиад орж ирээд байгаа юм. Зураг, төслийн ажил юм уу, өргөтгөл шинэчлэлийн ажил юм уу? Монголын хууль тогтоомжид заасан худалдан авах ажиллагаа явуулахгүйгээр Монголын эрх ашиг, эрх олгогдсон байгууллага Оросын талын эрх олгогдсон байгууллагатай зураг, төслийн гэрээ байгуулна. Энийг одоо юу гэж ойлгох вэ? Нөгөө манай Тендерийн хууль болбол энд хамаагүй гэж ойлгох уу юу гэх вэ? Энийг бас нэг жосоохон дэлгэрэнгүй. Тэгээд энэ явж байснаа өргөтгөл бүүр шинэчлэлийн гэрээ болоод явчих юм, энэ чинь зураг, төслийн гэрээ гэж явж байснаа ар тал дээрээ 4 дүгээр зүйл дээр бол өргөтгөл, шинэчлэлийн гэрээ болоод явчхаж байгаа. Тэгээд би энийг заримыг нь болбол протоколд оруулах зорилгоор одоо энийг бол зураг, төслийн боловсруулалтын үр дүнд гүйцэтгэгч болон захиалагч Дулааны гурав дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үнэ ба хэрэгжүүлэх боломжит хугацааг тодорхойлно гээд. Энэ одоо бас яг хэзээ юм бол гэдгийг нь тодорхойлох гээд. Энэ 4 дүгээр бүлгийн бас нэг сүүлийн хэсэгт нь яг одоо бид нар энд бичсэнээр нь ойлгож болох уу гэж тодруулж асуух гээд байгаа юм.

5 дугаар зүйл дээр Дулааны гурав дугаар цахилгаан станцын өргөтгөл,

шинэчлэл хэрэгжүүлэх болон зураг, төсөл боловсруулах хүрээнд ОХУ-ын эрх олгогдсон байгууллага, түүний Монгол Улсын нутаг дэвсгэр дээрх төлөөлөгчийн газар, салбар, эсвэл охин компани, туслан гүйцэтгэгч, тэдгээрийн гэрээт гүйцэтгэгч нарын ажилчид Монгол Улсын нутаг дэвсгэр дээр саадгүй нэвтрэх, орох гарах, оршин суух, ажиллахад шаардлагатай бүх нөхцөлийг бүрдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ гээд. Тэртээ тэргүй энэ чинь визгүйгээр орж ирээд ажлаа хийгээд явна эсвэл одоо нөгөө шаардлагатай визээ мэдүүлээд аваад ороод ирэхэд болно гэж бодож байсан чинь энд болохоор давуу эрх олгоно гэдэг нь одоо дэмжлэг үзүүлнэ гэдэг нь одоо энэ давуу эрх үзүүлэх гээд байгаа юу гэдгийг бас нэг тодруулах шаардлагатай байна.

Дээр нь Орос хэлийг давуу хэл болгож ашиглана гээд байгаа. Энэ чинь Монгол Оросын хооронд хэлэлцээ хийгдэж байж яагаад нэгийг нь давуу байдалтай ашиглах гээд байгаа юм бэ? Тэгээд зураг, төсөлтэй холбоотой ОХУ-ын норм дүрэм стандартын дагуу зураг, төсөл боловсруулахыг баталгаажуулах, Монгол Улсын хууль тогтоомжийг одоо бид нар болбол зүгээр харгалзан үзнэ гээд, нөгөөдүүл нь болохоор баталгаажуулна гээд яваад байгаа байхгүй юу. Тэгээд энэхүү хэлэлцээрт гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ОХУ-ын норм дүрэм стандартын дагуу Оросын холбооны улсаас үйлдвэрлэсэн, нийлүүлсэн энэ нөгөө бусад улсын шинэ технологи ч юм уу, одоо зардал багатай юм уу, хүчин чадал сайтай юмнуудыг одоо энэ чинь ашиглаж болохгүй гэж заах гээд байгаа юм уу?

Ц.Даваасүрэн: Чойжилсүрэн гишүүн Цогтбаатар гишүүний асуултад хариулъя.

Б.Чойжилсүрэн: Цогтбаатар гишүүний асуултад хариулъя. Та яг зарим зүйлийг зөв ойлгосон байна. Энэ олон улсын гэрээ байгуулагдана. Монгол Улсын Тендерийн тухай хууль энэ гэрээ

байгуулагдсан тохиолдолд болбол үйлчлэхгүй нэг. ОХУ-ын экспортын зээлээр санхүүжүүлнэ гэдэг ийм тохиролцоотой явж байгаа. Экспортын зээл нь өөрөө татаастай байдаг. Та өөрөө мэдэж байгаа. Хүүгийн татаастай хугацаа урт ийм зээлийг бид нар авна гэдгээ илэрхийлж байгаа.

Зээлийн яг нөхцөл дээр болбол яг эцэслэн тохироогүй, үнэ бас өндөр ирчихсэн 1 тэрбум 326 сая еврогоор хийнэ гэдэг ийм ТЭЗҮ-ийг Оросын талаас ирүүлсэн. Бид нар зөрүүлээд ийм өндөр үнэтэй хийлгэж чадахгүй, үнээ бууруул гэдэг ийм саналыг тавьдаг. Тэгэхлээр Оросуудад зөрүүлээд урдаас тэгвэл яг зураг, төсвөө эцэслээд хийчихье. Тэгсэн тохиолдолд болбол үнэ тодорхой болно, үнэ буулгах тухай асуудал ярина гэдэг ийм одоо хариулт өгч байгаа. Тийм учраас одоо энэ эхний энэ удаадаа болбол зөвхөн зураг, төсөв боловсруулах гэрээ шүү. Гэхдээ энэ мөнгө, энэ зарцуулсан эх үүсвэр маань дараа нь Монголын талын Оросууд болбол 85, 15-аар санхүүжүүлнэ гээд байгаа, бид нар болбол 95, 5-аар санхүүжүүлчхээч гэдэг ийм одоо хүсэлтийг тавиад байгаа юм Оросын Сангийн яаманд. 5 хувийг нь Монголын тал санхүүжүүлнэ, 95 хувь зээлээр санхүүжүүлнэ, хөнгөлөлттэй эх үүсвэр гээд.

Тэгэхээр бид нарын тэр Монголын талын оролцоо 5 гэнэ үү, 15 гэнэ үү ирээдүйд бий болох энэ мөнгө болбол тэрэнд орж тооцогдоно. Төслийнхөө өртөг ТЭЗҮ дотроо бас ороод суучихсан байгаа ийм. 19,8 орчим сая долларын үнэтэй ажил хийгдэх болов уу гэж бодож байгаа. Мэдээж энэ юу барилга угсралтын ажил хийхийн өмнө тэр ТЭЦ 3 дээр чинь одоо хөрсний шинжилгээ хийнэ. Тэр шинжилгээний үнийн дүнгээс шалтгаалаад түвэгшлийн түвшин нь тодорхой болно. Аль болох хямдруулах талаар ажиллаж байгаа ийм л зүйл. Та яг зөв, ийм төслүүд байгаа.

Ер нь бол манай бид нар болбол нэг яах вэ 400 мтв-таар дулаан нь, цахилгаан нь болбол 300мвт-ын хүчин чадалтай шүү дээ. Ерөнхийдөө 2 станц баригдана гэсэн үг. Эхний ээлжид 50 юу цахилгаанаар 50мвт-ын блок, дулаанаар 100мвт-ын блокыг эхлээд нэг барчихна. Тэрний дараа одоо ТЭЦ 3 дээр байгаа хугацаа нь ашиглалт дуусчихсан байгаа 12, 4-ийг үржих 12 турбин зуухын хамт бууна. Тэгэхээр энэ буусан газар дээр нь 2-ыг үржих 125-ын 2 турбин холбогдох зуухны хамт баригдаж, ашиглалтад орох ийм л сэдэв. Энэтэй холбоотой хуваарилах байгууламжууд болон нөгөө гадна шугам сүлжээтэй холбогдох ажлуудыг болбол зураг, төсөв дээр бүгдийг нь тооцсон байгаа.

Ц.Даваасүрэн: Батболд гишүүн асуултаа асууя.

Р.Батболд: 2 зүйл асуучихъя. Энэ нөгөө өргөтгөл нь өөрөө зөвхөн Оросын технологиор явах гээд байна уу гэдэг нэг асуулт байгаа юм. Зүгээр мэргэжлийн улсууд болохоор ярихаараа.../үг тасрав/

Ц.Даваасүрэн: Түрүүн бас тэгж асуусан шүү. Тэрийг нь чи дутуу хариулчихъя л даа.

Р.Батболд: Харин тийм. Мэргэжлийн улсууд ярихаараа болохоор энэ чинь одоо манай 3, 4 дүгээр цахилгаан станцад 20-оод жилийн өмнө нөгөө Япончууд нэг шинэчлэлт хийсэн шүү дээ. Тэрүүгээр л амьдарч байгаа. Түүнээс дангаараа нөгөө технологи нь Орос байсан бол аль хэзээний баларчихсан шүү дээ гэдэг нэг юм яриад байдаг. Тэгээд энэ дээр зөвхөн Оросын технологи ашиглах юм уу гэдэг нэг юм байгаа.

Ер нь бол мэдээж энэ шинэчлэлтийг хийх ёстой болчихоод байгаа. Тэгэхээр энэ энэ замын зураглал дээрээ тэр одоо 26 оны 3 дугаар улиралд өргөтгөлийн тухай гэрээнд гарын үсэг зурна гээд, энэ 2 жилийн дараа гэрээндээ гарын үсэг зурах юм уу гэдэг нэг асуудал.

Энийг нааилуулах хурдасгах арга байдаг юм уу? Ийм 2 асуулт байна.

Ц.Даваасүрэн: Чойжилсүрэн гишүүн хариулт өгье.

Б.Чойжилсүрэн: Батболд гишүүний асуултад хариулъя. Батболд гишүүнд та яг зөв ойлгосон байна. Энэ ОХУ-ын экспортын зээл учраас зөвхөн ОХУ-ын технологи ашиглагдана. Оndoо улсын технологиуд ашиглагдахгүй. Бид нарт байгаа боломж л энэ. Одоо тэр 2015 оны юу Парисын хэлэлцээрээр нүүрсний төслийг санхүүжүүлдэг барууны улс орнууд байхгүй болсон. 2021 онд Хятад Улсын дарга Ши Жиньпин дарга НҮБ-ын чуулган дээр Хятад Улсын газар нутагт, газар нутгаас гадна нүүрсний цахилгаан станцыг санхүүжүүлэхгүй гэдгээ бол олон нийтэд илэрхийлчихсэн. Энэ нь одоо Хятадын бүх шатны төрийн байгууллагуудын шийдвэр болчихсон байгаа. Одоо нүүрсний станц дээр санхүүжилт босгоно гэдэг бол айхтар хүнд болчихсон ийм сэдэв. Урьд нь байсан боломж магадгүй 90, 90 орчим хувиар хумигдсан ийм л байгаа. Бид нар төсөл үүгээр Оросуудтай нийлээд энийг хэрэгжүүлэх эс бөгөөс хэрэгжүүлэхгүй байх нэг.

2 дугаарт энэ удаа болбол зөвхөн зураг, төсвийн гэрээ байгуулагдаж байгаа юм. Зураг, төсөв байгуулаад дууссан, хийгээд дууссаны дараа үнийг эцэслэн тохирох юм. Би түрүүчийн асуултад хариулсан Цогтбаатар гишүүний асуулт дээр. Та зөв ойлгосон байна. Зөвхөн Оросын технологи ирнэ.

Ц.Даваасүрэн: Асуулт асууж дууссан. Үг хэлэх гишүүн байна уу? Нэрээ өгөөрэй. Түвшин гишүүн үг хэлье.

Б.Түвшин: Энэ зураг, төслийн хэлэлцээр учраас бас яах вэ зарим нэг зүйлийг бас хэлье л гэж бодож байна. Энэ одоо Дулааны цахилгаан станц 3 чинь одоо тусдаа үйл ажиллагаагаа бие даагаад явуулж байгаа учраас яг тэр

объектын ашиг сонирхол руу энэ зээлтэй холбоотой гаднын ашиг сонирхол бол орох вий. Тийм учраас энэ одоо нэг талаасаа нүүрсний цахилгаан станцаа нэмэгдүүлэх, хүчин чадлыг нэмэгдүүлэх нь зөв юм шиг боловч энэ гео стратегийнхаа хувьд болбол бас энэ талаас манай өөрийн бие даасан объект дээр орж ирж байгаа гэдэг талаас нь дараа дараагийн гэрээ, хэлэлцүүлгүүд дээрээ анхаармаар санагдаж байгаа юм.

Хоёрдугаарх асуудал нь болохоор энэ олон улсын гэрээ хэлэлцээр ч гэсэн валютын хувьд рублиэр илэрхийлэгдэх үү, цаашидаа ер нь ямар валютаар илэрхийлэгдэх вэ? Энэ чинь зээл болоод явчих юм болбол Оросын Холбооны Улс, Монгол Улсын нэг бол төгрөгөөр, нэг бол рублиэр л илэрхийлэгдэх болов уу л гэж бодож байна. Одоо ялангуяа энэ хөри орнуудын дангааршлын асуудал яригдаж байгаа учраас. Энэ 2 асуудлыг дараа дараагийн гэрээ хэлцэл дээрээ анхаараарай гэж хэлэх байна.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр энэ төсөл бас намайг сайдаар ажиллаж байх үед ч яригдаж байсан юм байгаа юм. Би бас нэг хэдэн үг хэлчихье гэж бодож байна. Тэр үед яах вэ 250, 50-ийг нь бол Хятадын талаар хийлгэе гэдэг байсан 50мвт-ыг нь. Тэгээд Хятадуудын өнөөдөр манайд хийж байсан 50мвт-ын 1мвт-ын өртөг бол 1,5 сая доллар байгаа шүү дээ. Ер нь дэлхийн зах зээл дээр одоо хамгийн өндөр автоматажсан ухаалаг станцын 1мвт-ын өртөг 1 сая евро л байхгүй юу, 1 сая евро. Тэгээд миний үед бол 250-ийг 600 гаруй сая доллароор хийж өгье, еврогоор хийж өгье гэдэг байсан юм. Би 2 дахин үнэтэй байгаа учраас боломжгүй гээд тухайн үед нь болбол энийг явуулдаггүй байсан төсөл.

Одоо та бүхэн энэ танилцуулгаас уншвал байна шүү дээ 1,3 сая евро, тэрбум евро. 1,3 тэрбум евро. Энэ чинь 4 нугалчихсан байгаа байхгүй юу. Би тэр үед 2,3 дахин их байна гэж байсан бол одоо энэ чинь миний тэр хэлж байснаас 2

дахин их буюу дэлхийн зах зээл дээр байгаа 1мвт-ын өртгийг 4 дахин нугалчихсан гэсэн үг. Яах вэ Хятадуудын манайд энэ нийлүүлсэн байгаа 50мвт-уудын өргөтгөлийн зуухтай өргөтгөлийг нь ингээд аваад үзээд ингээд явал 1,5 гэж бодвол доллароор шүү 3 дахин нугалчихсан байгаа байхгүй юу. Тэгэхээр ийм зүйлийг бол авах боломжгүй байсан учраас энэ өнөөдрийг хүртэл ингэж яригдаж байгаа.

Зүгээр сая болбол бас ямар технологиор хийх юм бэ гээд байгаа юм. Зүгээр бид нар энэ хуучин ер нь нөгөө Зөвлөлт Холбоот Улсын үед л энэ техникийн шаардлага норм нормативаа боловсруулчихсан учраас үндсэндээ бараг тэр хэмжээндээ байдаг байх. Нэг их шинэчлэгдээгүй байх гэж би бодож байна. Ер нь зүгээр зуухыг нь болбол уг нь арай өөр шинэ технологиор хийхээр байсан юм. Одоо тэгээд ямар технологиор хийх гэж байгаа юм мэдэхгүй. Уг нь бол нэлээн, тийм зуух нь нэг тийм нэг евро стандартын Хятад зуух тавихаар байсан тэр нь хэвээрээ юм байна. Нэг ийм, бусад нь бол нөгөө хуучин Оросын гээд энэ технологийнхоо дагуу явагдах юм байна.

Миний зүгээр одоо бодож байгаагаар болбол энэ зээлийн хэлэлцээрийг яах вэ дэмжих нь зүйтэй нэг л үндэслэл байгаа юм. Одоо өртгийг нь гаргах гэж байгаа юм байна гэж тийм ээ. Яагаад гэвэл зураг, ТЭЗҮ-г нь боловсруулах гэж байна шүү дээ. Тэгэхээр энэ ТЭЗҮ-г нь боловсруулаад ирэхээр ямар өртөгтэй гарах вэ? Тэрний дараа зээлийн хэлэлцээр тэртээ тэргүй одоо ЗГ-аас Их Хуралд 2 удаа орж ирж гарах учраас тэр үед нь ярьж болох байх гэдэг агуулгаар би бол дэмжиж байгаа юм.

Нөгөө талаар болбол эрчим хүчний дутагдалд бол сүүлийн 2 жил бол бид нар орчихсон байгаа. Жилдээ бараг 80-аас 100 мвт-аар хэрэглээ нэмэгдэж байгаа байх бүр багадаа. Нэг айл ороход, нэг байшин ороход чинь тэгээд л зурагт, хөргөгч,

плитк гээд л ингээд л явж өгнө шүү дээ. Компани ороход бүр илүү. Гэтэл жилдээ 100мвт-ын эх үүсвэр бид нар барих шаардлагатай болчихсон байхгүй юу жилдээ өнөөдрийн бидний хэрэглэж байгаа хэрэглээний өсөлт бол. Гэтэл бид нар сүүлийн 3 жилд юу ч бариагүй. Одоо яах вэ өнгөрсөн жил 150мвт-ын нарны станц орсныг эс тооцвол. Одоо Чойбалсангийн 50 орох байх. Ингээд үзвэл бид нар чинь ерөөсөө жилдээ 100мвт-ын эх үүсвэр барих юмаа барьж чадахгүй яваад байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ бол зайлиггүй хийгдэх ёстой ажил байгаа юм уг нь. Тэгэхдээ мэдээж одоо зах зээлийн үнээр байх ёстой. Тэр талаасаа би энэ ТЭЗҮ, зураг, төсөв нь хийгдсэний дараа шийдэгдэх байх гэж ингэж найдаж байна. Ингээд гишүүд үг хэлж дууслаа.

Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Дулааны гурав дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах хэлэлцээрийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт явуулж дууслаа. Монгол Улсын Засгийн газар, Оросын, би нөгөө юу дунг нь танилцуулна. 16 гишүүн оролцож, 10 гишүүн 62,5 хувиар санал дэмжигдлээ.

Санал дэмжигдсэн тул Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Дулааны гурав дугаар цахилгаан станцын өргөтгөл, шинэчлэлийн төслийн үндсэн зураг, төсөл боловсруулах тухай хэлэлцээрийн төслийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооноос гаргах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулна. Монгол Улсын Засгийн газар, Оросын Холбооны Улсын Засгийн газар хоорондын Дулааны гурав дугаар цахилгаан станцын өргөтгөл,

